

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/99/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022. 02. 18 № 2/23

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Б.ОЮУТБОЛД ТАНАА

танай _____ -ны № _____ -г

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D- alban bichig 2022 A4 TOOT


0050?0240

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A red official stamp of the Mongolian Audit Agency (ADA) is centered on the page. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГУУС" (Mongolian Audit Agency) and a central logo. A handwritten signature in black ink is written over the stamp. A long, thin black line is drawn across the signature and the stamp.

Б.МӨНХБАТ

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	216,595,902.32	258,193,864.05
33	АВЛАГА	2,000,000.00	44,027,641.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	44,027,641.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	213,595,902.32	214,166,223.05
351	Түүхий эд материал	90,774,343.92	91,282,859.65
35110	Тусгай зориулалттай материал	88,412,996.92	88,491,239.65
35130	Эм боох материал	2,361,347.00	2,791,620.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	630,000.00	630,000.00
354	Хангамжийн материал	64,845,223.40	61,798,754.40
35410	Бичиг хэргийн материал	15,360,408.00	3,415,275.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,479,500.00	1,479,500.00
35440	Түлш, шатах тослох материал	5,828,023.00	14,907.00
35450	Барилгын засварын материал	878,000.00	11,320,000.00
35470	Бусад хангамжийн материал	41,299,292.40	45,569,072.40
35600	Мал амьтад	57,346,335.00	60,454,609.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,830,680,786.15	3,954,395,500.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,830,680,786.15	3,954,395,500.67
392	Биет хөрөнгө	3,567,262,786.15	3,690,977,500.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,401,696,347.05	3,378,746,447.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-239,498,160.22	-324,061,318.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	427,271,194.04	637,407,135.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-344,369,299.48	-304,709,442.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	509,128,706.27	591,201,634.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-251,866,849.75	-333,663,728.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,410,400.40	88,010,400.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,815,188.16	-71,259,262.11
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	29,305,636.00	29,305,636.00
393	Биет бус хөрөнгө	263,418,000.00	263,418,000.00
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-725,000.00	-725,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	263,418,000.00	263,418,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,046,276,688.47	4,212,589,364.72
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,046,276,688.47	4,212,589,364.72
51	Засгийн газрын хувь оролцоо	4,046,276,688.47	4,212,589,364.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	975,948,623.99	975,948,623.99
51101	Өмч: - төрийн	975,948,623.99	975,948,623.99
512	Хуримтлагдсан үр дүн	2,602,516,465.85	2,786,378,228.90
51210	Өмнөх үеийн үр дүн	2,602,516,465.85	2,620,065,552.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	166,312,676.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	467,811,598.63	450,262,511.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,046,276,688.47	4,212,589,364.72

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,948,854,875.47	3,448,578,969.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	274,455,275.47	484,494,177.71
120	Нийтлэг татварын бус орлого	270,770,602.47	484,494,177.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,428,760.00	113,255,020.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,343,712.00	93,742,933.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,085,048.00	19,512,087.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	130,914,898.47	325,055,538.98
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	45,426,944.00	46,183,618.73
122	Тусламжийн орлого	3,684,673.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	3,684,673.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,674,399,600.00	2,964,084,792.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,566,625,200.00	2,760,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,566,625,200.00	2,760,862,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107774400.00	203222492.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,600,000.00	131,894,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	82,174,400.00	71,328,492.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,998,165,365.96	3,263,659,577.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,998,165,365.96	3,263,659,577.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,983,240,689.96	3,237,393,007.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,224,451,393.00	2,397,470,026.00
210101	Үндсэн цалин	1,351,069,060.00	1,459,836,423.00
210102	Нэмэгдэл	810,597,963.00	870,463,192.00
210105	Гэрээт ажлын хөлс	62,784,370.00	67,170,411.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,325,819.00	51,420,116.00
210201	Тэтгэврийн даатгал	2,064,910.00	2,069,827.00
210202	Тэтгэмжийн даатгал	238,739.00	232,663.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	198,537.00	186,131.00
210204	Ажилгүйдлийн даатгал	48,586.00	46,531.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,775,047.00	48,884,964.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,645,100.00	172,404,800.00
210301	Гэрэл, цахилгаан	25,826,301.00	18,426,532.00
210302	Түлш, халаалт	110,475,543.00	134,212,832.00
210303	Цэвэр, бохир ус	13,343,256.00	19,765,436.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,326,431.00	157,353,456.00
210401	Бичиг хэрэг	21,349,500.00	22,521,980.00
210402	Тээвэр, шатахуун	84,589,863.00	115,171,126.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,896,308.00	9,542,350.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800,760.00	9,368,000.00
2105	Нормативт зардал	38,754,465.00	56,470,077.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,498,353.00	15,347,877.00
210502	Хоол, хүнс	35,716,112.00	40,990,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540,000.00	132,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,405,352.00	45,307,457.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,937,952.00	1,231,000.00
210604	Урсгал засвар	29,467,400.00	44,076,457.00
2107	Томилолт, зочны зардал	11,130,000.00	7,930,000.00
210702	Дотоод албан томилолт	11,130,000.00	7,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,051,046.00	92,701,295.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,287,122.00	76,341,312.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,000.00	1,855,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	730,000.00	484,000.00

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	698,500.00	00.00
210807	Газрын төлбөр	550,000.00	550,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	370,424.00	13,470,983.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,151,083.96	256,335,780.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	936,972.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,566,211.10	1,764,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	239,584,872.86	253,634,108.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,924,676.00	26,266,570.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,300,000.00	4,420,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	3,920,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,285,268.00	21,846,570.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,285,268.00	21,846,570.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	339,408.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	339,408.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-49,310,490.49	184,919,392.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	18606716.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	18,606,716.40
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(18,606,716.40)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	166,312,676.25

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,758,743,312.00	3,059,827,725.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,343,712.00	93,742,933.00
120	Нийтлэг татварын бус орлого	84,343,712.00	93,742,933.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	84,343,712.00	93,742,933.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,343,712.00	93,742,933.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,674,399,600.00	2,966,084,792.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,566,625,200.00	2,760,862,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,566,625,200.00	2,760,862,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,774,400.00	205,222,492.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,600,000.00	131,894,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	82,174,400.00	73,328,492.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,752,364,412.00	2,988,927,725.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,752,364,412.00	2,988,927,725.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,735,439,736.00	2,962,661,156.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,224,263,424.00	2,397,579,900.00
210101	Үндсэн цалин	1,222,795,000.00	1,310,421,800.00
210102	Нэмэгдэл	969,546,324.00	1,050,815,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,922,100.00	36,342,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,152,220.00	51,444,563.00
210201	Тэтгэврийн даатгал	1,886,783.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	217,783.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	181,772.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	44,395.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,821,487.00	51,444,563.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,645,100.00	172,404,800.00
210301	Гэрэл, цахилгаан	25,826,301.00	20,173,000.00
210302	Түлш, халаалт	110,475,543.00	134,212,832.00
210303	Цэвэр, бохир ус	13,343,256.00	18,018,968.00
2104	Хангамж, бараа материалын зардал	120,242,300.00	121,842,300.00
210401	Бичиг хэрэг	19,494,000.00	18,872,000.00
210402	Тээвэр, шатахуун	83,866,300.00	87,716,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,302,000.00	9,674,130.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00

**Баянхонгор аймаг дахь Шагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800,000.00	4,800,000.00
2105	Нормативт зардал	34,287,100.00	35,887,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	564,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	32,587,100.00	35,087,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,136,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,770,000.00	31,570,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,800,000.00
210604	Урсгал засвар	27,770,000.00	27,770,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,130,000.00	7,930,000.00
210702	Дотоод албан томилолт	11,130,000.00	7,930,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,449,592.00	141,502,492.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,056,092.00	138,367,492.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,000.00	1,855,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	730,000.00	730,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	698,500.00	00.00
210807	Газрын төлбөр	550,000.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,924,676.00	26,266,570.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,300,000.00	4,420,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	3,920,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,285,268.00	21,846,570.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,285,268.00	21,846,570.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,339,408.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,339,408.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,378,900.00	70,900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (6)	6,378,900.00	70,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,378,900.00	70,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,378,900.00	70,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,378,900.00	70,900,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,378,900.00	-70,900,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,651,826,956.34	4,095,587,178.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,651,826,956.34	4,095,587,178.96
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-49,310,490.49	-49,310,490.49
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,602,516,465.85	4,046,276,688.47
D01	2021 оны 01-р сарын 30-нээрх үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,602,516,465.85	4,046,276,688.47
D02	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	17,549,086.80	17,549,086.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	975,948,623.99	467,811,598.63	2,620,065,552.65	4,063,825,775.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-17,549,086.80	00.00	-17,549,086.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	166,312,676.25	166,312,676.25
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	975,948,623.99	450,262,511.83	2,786,378,228.90	4,212,589,364.72

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,832,780,300.00	2,832,758,663.00	21,637.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,832,780,300.00	2,832,758,663.00	21,637.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,828,360,300.00	2,828,338,663.00	21,637.00	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,397,580,100.00	2,397,579,900.00	200.00	100.0
210101	Үндсэн цалин	1,310,421,800.00	1,310,421,800.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	1,050,815,800.00	1,050,815,600.00	200.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	36,342,500.00	36,342,500.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,466,000.00	51,444,563.00	21,437.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	51,466,000.00	51,444,563.00	21,437.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,404,800.00	172,404,800.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	27,482,600.00	20,173,000.00	7,309,600.00	73.4
210302	Түлш, халаалт	132,948,300.00	134,212,832.00	1,264,532.00	101.0
210303	Цэвэр, бохир ус	11,973,900.00	18,018,968.00	6,045,068.00	150.5
2104	Хангамж, бараа материалын зардал	121,842,300.00	121,842,300.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	19,494,000.00	18,872,000.00	622,000.00	96.8
210402	Тээвэр, шатахуун	86,766,300.00	87,716,170.00	-949,870.00	101.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,002,000.00	9,674,130.00	327,870.00	96.7
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	35,887,100.00	35,887,100.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	35,087,100.00	35,087,100.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,570,000.00	31,570,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	27,770,000.00	27,770,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,930,000.00	7,930,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	7,930,000.00	7,930,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,180,000.00	7,180,000.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,045,000.00	4,045,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,855,000.00	1,855,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	730,000.00	730,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	550,000.00	550,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00	0.00	100.0

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4420000.00	4420000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,420,000.00	4,420,000.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,920,000.00	3,920,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,832,780,300.00	2,832,758,663.00	21,637.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,760,862,300.00	2,760,840,663.00	21,637.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,760,862,300.00	2,760,840,663.00	21,637.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	71,918,000.00	71,918,000.00	0.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,918,000.00	71,918,000.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	159.00	159.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	154.00	154.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,434,992.00	205,222,492.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,434,992.00	205,222,492.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,434,992.00	205,222,492.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,434,992.00	205,222,492.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,434,992.00	205,222,492.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	105434992.00	205222492.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	105434992.00	205,222,492.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,600,000.00	131,894,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	79,834,992.00	73,328,492.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 25 өдрийн 29-1/494 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын дарга Цагдаагийн хурандаа Б.Оюутболд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ нар зурж байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь "Хуулийг дээдлэн, хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах" эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагдаагийн Ерөнхий газрын хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,998,165.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,981.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,987.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 32,636.6 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 4,212,589.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 166,312.7 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	215,595.9	290,193.9	74,598.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,000.0	44,027.6	42,027.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	213,595.9	246,166.2	32,570.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,830,680.8	3,922,395.5	91,714.7
Үндсэн хөрөнгө	4,717,955.3	4,956,814.3	238,859.0
Хуримтлагдсан элэгдэл	(887,274.5)	(1,034,418.8)	(147,144.3)
Нийт хөрөнгө	4,046,276.7	4,212,589.4	166,312.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,046,276.7	4,212,589.4	166,312.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,046,276.7	4,212,589.4	166,312.7

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Авлагын дансны 44,027.6 мянган төгрөг болж 42,027.6 мянган төгрөгөөр өссөн нь Баянхонгор аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас суудлын автомашин, Led дэлгэц худалдан авахад зориулж нэмэлт санхүүжилтийн дансанд 90,000.0 мянган төгрөг санхүүжүүлснээс Led дэлгэцийг худалдан авахаар "Монтех Дистрибьюшн" ХХК-д 2021.12.17-нд 44,000.0 мянган төгрөгийг шилжүүлж хөрөнгө ирээгүй тул авлага үүсгэснээс шалтгаалсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 246,166.2 мянган төгрөг болж 32,570.3 мянган төгрөгөөр өссөн нь барилгын засварын материал, бусад хангамжийн материал нэмэгдсэн энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой онцгой байдлын газраас 35,188.9 мянган төгрөгийн хангамжийн материал шилжүүлэн авсан, нас дэвшилт болон төл малын орлогоос 5626.8 мянган төгрөг орлого авсан, цагдаагийн байгууллага хооронд 10,994.8 мянган төгрөг бусад хангамжийн материал шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,956,814.3 мянган төгрөг болж 238,859.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 70,900.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 293,055.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авсан ба Аймгийн ИТХ-ын дараах тогтоолоор 125,096.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Шийдвэрийн нэр	Мөнгөн дүн	Хөрөнгийн нэр
1	Аймгийн ЗД-ын А/611 дугаар захирамж	11,840.0	машин тоног төхөөрөмж
2	аймгийн ИТХ-ын 2021.01.18-ний 07 дугаар тогтоол	87,508.1	Авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж
3	аймгийн ИТХ-ын 2021.02.11-ний 28 дугаар тогтоол	18,500.0	авто тээврийн хэрэгсэл
4	аймгийн ИТХ-ын 2021.04.01-ны 45, 2021.04.15-ний 60 дугаар тогтоол	22,996.5	авто тээврийн хэрэгсэл, камер
5	аймгийн ИТХ-ын 2021.09.17-ний 102 дугаар тогтоол	29,000.0	Авто тээврийн хэрэгсэл
6	Нийслэлийн ЗД-ын 2021.12.30-ний өдрийн А/1049	26,697.1	тоног төхөөрөмж
7	Нийслэлийн ЗД-ын 2021.12.30-ний өдрийн А/1050 албан тоот	25,624.3	Авто тээврийн хэрэгсэл
8	Нийслэлийн ЦГ-ын 2022.01.04-ний өдрийн 26/25 тоот	9,300.0	Авто тээврийн хэрэгсэл
9	ОНӨГ-ийн 2021.12.03 29-а/97 тоот зөвшөөрөл	23,540.0	тоног төхөөрөмж
10	ОНӨГ-ын 2021.03.16 ний өдрийн А/61 тоот зөвшөөрөл	27,180.0	тоног төхөөрөмж
11	ЦЕГ-ын даргын 2021.09.24-ний өдрийн А/229	10,869.6	тоног төхөөрөмж
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүн	293,055.6	
1	Аймгийн ИТХ-ын 2021.04.01-ны 43 дугаар тогтоол	22949.96	Барилга байгууламж
2	аймгийн ИТХ-ын 2021.04.01 -ны өдрийн 42 дугаар тогтоол	38500	Авто тээврийн хэрэгсэл
3	аймгийн ИТХ-ын 2021.10.15 өдрийн 117 дугаар тогтоол	46646.67	Авто тээврийн хэрэгсэл
4	аймгийн ИТХ-ын 2021.12.28 өдрийн 156 дугаар тогтоол	17000	Авто тээврийн хэрэгсэл
	Акталсан хөрөнгийн дүн	125096.63	

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,212,589.4 мянган төгрөг болж 166,312.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 166,312.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,082,584.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,082,584.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 33,312.5 мянган төгрөгөөр бууруулж 2,749,459.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 2,832,780.3 мянган төгрөг болгож 83,321.0 мянган төгрөгөөр буюу цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,832,780.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,760,862.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 71,918.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,760,840.7 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 71,918.0 мянган төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,832,758.7 мянган төгрөгийг зарцуулж улсын төсвөөс авах санхүүжилтээс 21.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 21,824.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,832,758.7 мянган төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 131,864.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнд аймгийн Засаг даргын 2021.03.04-ны өдрийн А/167, 2021.08.02-ны өдрийн А/480 дугаар захирамжуудаар Land-200 маркийн автомашины засварт 35,182.0 мянга, Заг, Баянцагаан сумын Кобоны засварт 3,212.0 мянга, аймгийн Засаг даргын 2021.08.3-ний өдрийн 1а/543 дугаар албан бичгээр аймгийн ОНХС-гаас 90,000.0 мянга, мал мах-2021 арга хэмжээнд 3,500.0 мянган төгрөгийн зарцуулах шийдвэр гарч зарцуулсан байна.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 73,328.5 мянган төгрөгийн нэмэлт орлого төвлөрсөн байна. Үүнд галт зэвсгийн сургалтын төлбөрийн орлогоос 11,158.4 мянга, хуучин байрны түрээсийн орлогоос 4,601.6 мянга, ноолуурын орлого 1,871.0 мянга, харуул хамгаалалтын орлогоос 3,300.0 мянга, Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 9,992.0 мянга, гэрээгээр ажилласан хүмүүжигчдийн төлбөр 874.0 мянга, Шинэжинст сумын ИТХ-аас олон нийтийн цагдаа нарын хувцасны үнэнд 300.0 мянга, Практикал даатгалаас даатгалын төлбөрт 2,600.1 мянга, урд оны давсан орлогоос 2,000.0 мянга, Сангийн сайдын 2021.12.10-ний өдрийн 217 дугаар тушаалаар 2021 оны үйл ажиллагааны орлогоос 1,666.4 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Г.Нарангэрэл аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 5 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 99.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3,263,659.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 265,494.2 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хопшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал тус тус нэмэгдсэн, томиллолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 4,642,632.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	35	1	
5	Тухай бүр	8	96	94	2	
	Нийт	27	151	146	3	2

хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 8 сарын мэдээлэл, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 8 сарын мэдээлэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 12 сарын мэдээллийг дахиж орсноос шалтгаалж хоцорсон төлөвтэй байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх заалтад Цагдаагийн газрыг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн байгууллага гэж заасан тул Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд хамааралгүй болно.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг 2021.09.22-ны өдрийн 29-1/1238 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын биет бус хөрөнгөнд 192,325.0 мянган төгрөгийн өртөгтэй 7,693 м3 газар бүртгэлтэй бөгөөд аймгийн Цагдаагийн газрын хүсэлтийн дагуу аймгийн Засаг Даргын 2021.01.27-ны өдрийн А/166 дугаар захирамжийг үндэслэн 6293м2 газрын зориулалтыг албан конторын, 1400м2 газрын зориулалтыг нийтийн орон сууц болгон өөрчилж 000004178 дугаар газар эзэмших эрхийн гэрчилгээг 2021.01.27-ны өдөр олгосон байна.

Мөн Цагдаагийн Ерөнхий газрын санхүү аж албаны 2021.02.26-ны өдрийн 6/306 дугаар албан тоотор Цагдаагийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор байгууллагын эзэмшил газарт хөнгөлөлттэй үнээр орон сууц барьж, албан хаагчдыг хамруулах хүсэлтэд татгалзах зүйлгүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах гэсэн хариуг ирүүлсэн байна.

Иймд дээрх газрын зориулалтыг өөрчилсөн нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, мөн нягтлан бодох бүртгэлд зориулалтын дагуу бүртгэх эсэхийг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 76,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч санхүүгийн тайланд залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

1.Тайлант онд Аймгийн засаг даргын 2021.08.31-ний өдрийн 1а/543 дугаар албан бичгийн дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Цагдаагийн газрын албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай автомашин, LED дэлгэц худалдан авахад зориулж

**Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

90,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулан “Монтех Дистрибьюшн” ХХК-д 44,000.0 мянган төгрөгийг 2021.12.17-нд шилжүүлж хөрөнгө хүлээн аваагүй байхад тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ын 4.15 Бараа материал, 4.30 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 44,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Led дэлгэцийг хөрөнгийн данснаас хасаж авлага дансанд бүртгэж санхүүгийн тайланд залруулав.

2. Аймгийн Засаг даргын 2021.08.18-ны өдрийн А/515 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 32,000.0 мянган төгрөгийг Цагдаагийн газрын автомашин худалдан авах ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж автомашиныг 2021.09.20-ны өдөр хүлээн авсан байна. Гэвч хөрөнгө орлого авах шийдвэр гараагүй гэх шалтгаанаар хөрөнгөнд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018.05.02-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3-т “ Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч эзэмшигч байгууллага нь шууд данс бүртгэлдээ тусгана” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Оршин байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгөөр бэлтгэсэн 32,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Nissan Caravan авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэж санхүүгийн тайланд бүртгэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Запруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	2	76,000.0							2	76,000.0

оОо